

**МОНГОЛ УЛС “АНТАРКТИДИЙН ТУХАЙ ГЭРЭЭ”-НД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ  
АСУУДЛЫГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 4 дүгээр  
сарын 8-ны өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улс “Антарктидийн тухай гэрээ”-нд нэгдэн орох тухай асуудал зөвшилцөхөөр ирүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2014 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг асуудлыг хэлэлцүүлэхэд Улсын Их Хурлын гишүүн Н.Энболд, Л.Цог, Н.Номтойбаяр нар гэрээнд нэгдэн орох асуудлыг дэмжсэн болно. Улсын Их Хурлын гишүүн Л.Цог “Антарктидийн тухай гэрээ”-нд нэгдэн орсны дараа хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд Монгол Улс Антарктидэд өөрийн судалгааны багийг илгээж, зөвлөлдөх эрхтэй гишүүн болох боломжтой талаар санал гаргалаа.

Монгол Улс “Антарктидийн тухай гэрээ”-нд нэгдэн орох тухай асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, нэгдэн орохыг зөвшөөрөв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т заасны дагуу энэхүү санал, дүгнэлтийг гаргасан болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Ц.ОЮУНБААТАР**